ӨМГӨӨЛЛИЙН
НИЙСЛЭЛ
АДВОКЭЙТС
ХХН

# ТАНИЛЦУУЛГА

# НИЙСЛЭЛ АДВОКЭЙТС ХУУЛИЙН ФИРМЭЭС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

- ӨМГӨӨЛӨЛ, ТӨЛӨӨЛӨЛ
- ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ
- ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ
- ХУУЛЬ ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- ГЭРЭЭ, БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

# ҮНЭТ ЗҮЙЛС

## ГУРВАН ЧАНАД

- Мэргэшсэн, итгэлтэй, найдвартай, хариуцлагатай байхыг чандлан сахих
- Шударга байж  хууль, ёс зүйг хатуу баримтлан, зарчимч байхыг чандлан сахих
- Хараат бус байж хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг чандлан сахих

## ГУРВАН ДЭЭД

- Эрх зүйч мэргэжлийн эрхэм чанарт үнэнч байж үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах
- Өмгөөлөгчийн чиг үүрэгтээ үнэнч байж үйлчлүүлэгчийн нэр хүнд, бизнесийн нэр хүндийг дээдлэх
- Хуульчийн тангарагтаа үнэнч байж хүний эрхэм чанар, эрх эрх чөлөөг хүндлэн дээдлэх

## МАНАЙ ХУУЛИЙН ФИРМ НЬ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНААС ХОЙШ

- Монгол Улсын иргэн
- Гадаадын иргэн, харьяалалгүй хүн
- Монгол Улсын хуулийн этгээд /бүх төрлийн аж ахуй нэгж байгууллага, албан газар/
- Гадаадын хуулийн этгээд /гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж байгууллага, холбоо, нийгэмлэг, олон улсын байгууллага, элчин сайдын яам/,
- Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагуудад итгэлтэй, найдвартай, хариуцлагатай байж мэргэжлийн ёс зүйг чанд сахин, хувь хүн, хуулийн этгээдийн нууцыг задруулахгүй байх, үйлчлүүлэгчийн нэр хүнд, ашиг сонирхлыг дээдлэх зарчмуудыг баримтлан өмгөөлөл, хууль зүйн туслалцааг үзүүлэн ажиллаж байна.

## АЛСЫН ХАРАА

Бид өмгөөллийн салбарын өнгө, төрхийг тодорхойлсон хөгжингүй орны жишигт нийцсэн найдвартай, тэргүүн туршлагатай, чадварлаг үйлчилгээ бүхий орчин үеийн шилдэг хуулийн фирм байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүн, хуулийн этгээдийн үнэт зүйл болох эрх, эрх чөлөө, шударга ёс, хууль дээдлэх зарчим, Үйлчлүүлэгчийнхээ эрх ашиг сонирхлыг хуулийн хүрээнд тууштай хамгаалах зарчмуудыг чандлан сахиж

Монгол улсын хууль, эрх зүйн хөгжил, тэр дундаа өмгөөллийн үйлчилгээний салбарт бусад хуулийн нөхөрлөлүүдийг манлайлан оролцож, дэлхийн жишигт нийцсэн чанартай, итгэлтэй, хариуцлагатай үйлчилгээг бий болгоход оршино.



ӨМГӨӨЛЛИЙН САЛБАРЫН ӨНГӨ, ТӨРХИЙГ ТОДОРХОЙЛСОН ХӨГЖИНГҮЙ ОРНЫ ЖИШИГТ НИЙЦСЭН НАЙДВАРТАЙ, ТЭРГҮҮН ТУРШЛАГАТАЙ, ЧАДВАРЛАГ ХАМТ ОЛОН.

# ӨМГӨӨЛӨЛ, ТӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ
- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ
- Зөрчлийн хэрэг  хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ
- Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Эрүүгийн хэргийн чиглэлээр мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээ нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн улмаас хохирсон хувь хүн, хуулийн этгээдийн өргөдөл гомдлын эх бэлтгэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байлцах, мөрдөгч, прокурор, шүүгч зэрэг албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаанд гомдол гаргахаас бүрдэнэ.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн улмаас хувь хүн, хуулийн этгээдийн эрх ашиг сонирхол хөндөгдсөн, эд хөрөнгөнд нь хохирол учирсан бол түүнийг сэргээлгэх, нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудалд өмгөөллийн үйлчилгээ болон хууль зүйн туслалцаа үзүүлэхээс гадна дор дурдсан гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлнэ.



# ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

## ХУВЬ ХҮН-Д

- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг
- Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхдийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Авилгын эсрэг гэмт хэрэг
- Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
- Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг
- Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг
- Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг

## ХУУЛИЙН ЭТГЭЭД-Д

- Татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах, хууль бусаар дампууруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх гэх мэт эдийн засгийн эсрэг гэмт хэргүүд
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх гэх мэт олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг
- Хахууль өгөх, хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулах ашиглах гэх мэт авилгын эсрэг гэмт хэрэг
- Байгаль орчныг бохирдуулах, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, хууль бусаар мод бэлтгэх гэх мэт хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах, соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах гэх мэт соёлын өвийн эсрэг гэмт хэрэг
- Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих гэх мэт хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Террорист үйлдэл хийх, терроризмыг санхүүжүүлэх гэх мэт хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг

# ИРГЭНИЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛӨЛ, ТӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД-Д/



- Хүчин төгөлдөр бус хэлцлээс үүссэн маргаан
- Төлөөлөгч төлөөлүүлэгч нарын хооронд үүсэн маргаан
- Гэм хор учруулсантай холбоотой маргаан
- Бүх төрлийн гэрээ, хэлцлээс үүдсэн маргаан
- Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх, эзэмших, ашиглах зэрэг захиран зарцуулах эрхтэй холбоотой маргаан
- Бусдын хууль бус эзэмшил, ашиглалттай холбоотой маргаан
- Иргэн хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээхтэй холбоотой маргаан
- Компани, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн хооронд үүссэн маргаан
- Дундын өмчөөс үүсэх үүргийн маргаан
- Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөнтэй холбоотой маргаан
- Өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой маргаан
- Гэрлэлт цуцлалт, асран тэтгэх үүрэгтэй холбоотой маргаан
- Ажлаас үндэслэлгүй халагдсан, тэтгэмж тогтоолгохтой холбоотой маргаан болон хөдөлмөрийн хамтын маргаан
- Оюуны өмчийн маргаан



# ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД-Д/

**Захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нь хөндсөн үйлдэл эс үйлдэхүйтэй холбоотой хэрэг маргаанд захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, өмгөөлөгч нар өмгөөлөл, төлөөллийн үйлчилгээ үзүүлнэ. Мөн захиргааны байгууллага албан тушаалтнуудад захиргааны акт гаргах үйл ажиллагаанд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, хууль эрх зүйн дүгнэлт гаргана.**

- Иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, ашиглах, зэрэг захиран зарцуулах эрхтэй холбогдуулан захиргааны байгууллага албан тушаалтны хууль бус үйлдэл эс үйлдэлтэй холбоотой маргаан
- Бүх төрлийн татварын маргаан
- Тендер сонгон шалгаруулалт /худалдан авах ажиллагаа/-тай холбоотой маргаан
- Уул уурхай, ашигт малтмалтай холбоотой маргаан
- Бүх төрлийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаан
- Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой маргаан
- Оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой маргаан
- Улсын бүртгэлтэй холбоотой маргаан
- Сонгуулийн маргаан
- Хөрөнгө оруулалт, үнэт цаасны зах зээлтэй холбоотой маргаан
- Банк санхүү, даатгалтай холбоотой маргаан
- Илт хууль бус захиргааны акттай холбоотой маргаан
- Захиргааны гэрээтэй холбоотой маргаан
- Захиргааны хэм хэмжээний актаас үүссэн маргаан

# ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД-Д/

**Зөрчлийн тухай хуулиар хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн танд мэргэшсэн хуульч, өмгөөлөгч нар хууль зүйн зөвлөгөө өгч, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өмгөөллийн үйлчилгээ үзүүлнэ.**

- Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил
- Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил
- Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил
- Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил
- Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил
- Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, даатгалын журмын эсрэг зөрчил
- Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчил
- Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил
- Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил
- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил
- Монгол улсын хилийн аюулгүй байдлын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн монгол улсад зорчих журмын эсрэг зөрчил
- Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил



# АРБИТРЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД МЭРГЭШСЭН ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ /ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭД-Д/

**Арбитрын ажиллагаанд хувь хүн, хуулийн этгээдэд мэргэшсэн өмгөөллийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:**

- Талуудын хооронд арбитрын хэлэлцээр хийгдсэн эсэх
- Арбитрын харьяаллын маргаан мөн эсэх
- Арбитрын ажиллагаа, хуралдаан явуулах газар
- Маргаан шийдвэрлэхэд болон ажиллагаанд хэрэглэх эрх зүйн хэм хэмжээ
- Арбитрын ажиллагаа явуулах хэл
- Нээлттэй, хаалттай арбитрын хуралдааны хэлбэр
- Гэрч дуудах, шинжээч томилох, хэлмэрч, орчуулагч оролцуулах, нотлох баримт гаргуулах гэх зэргээр арбитрын урьдчилсан хуралдаан болон үндсэн хуралдаанд оролцох



## ТӨЛӨӨЛӨЛ

**Танд хэрэгцээт төлөөллийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд дараах чиглэлүүдээр үзүүлэн ажиллаж байна.**

- Урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд /шүүхийн өмнөх шатанд/ үйлчлүүлэгчийг төлөөлөх
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагч болон төлбөр төлөгчийг төлөөлөх
- Яам, тамгын газар, засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлаг зэрэг төрийн захиргааны байгууллага болон Нийслэлийн засаг захиргааны байгууллагад үйлчлүүлэгчийг төлөөлөх, хүсэлт, өргөдөл, гомдол гаргах
- Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны баримт бичгийн бүрдэл хангах, эрх бүхий байгууллагад төлөөлөх
- Иргэн, Захиргаа болон Арбитрын хэрэгт нэхэмжлэгч хариуцагч, гуравдагч этгээдийг төлөөлөх
- Үндсэн хуулийн цэцийн маргаанд мэдээлэл, гомдол гаргагчийг төлөөлөх



# ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

- АМААР
- БИЧГЭЭР
- НЭГ УДААГИЙН ЗӨВЛӨГӨӨ
- ӨДӨР ТУТМЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

**ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ**

Аливаа асуудлаар хууль зүйн дүгнэлт гаргуулах нь зардал хэмнэж эрсдэл бууруулдаг бөгөөд оновчтой шийдвэр гаргахад тань тусална.

“ХУУЛЬЧ БИД БОЛ ХУВИА БОДСОН ҮХЭЭНЦ БИШ, ХАРИН УУЖУУХАН БОДОЛТОЙ, ТЭВЧЭЭРТЭЙ, ЮМНЫ УЧРЫГ ЭРГЭЦҮҮЛЖ, ЗАРЧМАА БАРЬДАГ, ХАРАХАД ХАТУУ ДҮРТЭЙ Ч ХАНИЛАХАД БУСДЫН ТӨЛӨӨ УЯСЧ БАЙДАГ ХҮМҮҮС БИЛЭЭ.

***Б. ЧИМИД***”

# БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

**Аж ажуйн нэгж байгууллагын дотоодод мөрдөгдөх дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээ, тушаал, албан бичиг, гадны байгууллагуудтай хийх гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах.**

### ГЭРЭЭ, БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ

Хүн хуулийн этгээдэд хандсан албан бичгийн төсөл болон иргэний эрх, үүргийг бий болгож, өөрчилж, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр ба түүнээс дээш этгээдийн хооронд хийсэн тохиролцоо бүхий гэрээний төсөл боловсруулах

### ХУУЛЬ ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Салбар эрх зүйн чиглэлүүдээр ганцаарчилсан болон танхимын сургалт зохион байгуулах, Хуульчийн мэргэжлийн шалгалтад эрчимжүүлсэн хөтөлбөрөөр бэлтгэнэ.



# МАНАЙ ХУУЛИЙН ФИРМ НЬ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ДАРААХ БАГЦ ҮЙЛЧИЛГЭЭГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА.

## ХҮРЭЛ БАГЦ

- Өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар утсаар, цахим шуудангаар болон биечлэн уулзаж зөвлөгөө өгөх
- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, эрх зүйн актуудыг судалж холбогдох санал зөвлөмж боловсруулах
- Гэрээ, баримт бичгийн төсөл боловсруулах, хянах
- Үйлчлүүлэгчийн хүсэлтээр байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан эрх зүйн асуудлаар дүгнэлт гаргах

**НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ:**

- Эрүү, Иргэн, Захиргаа, Зөрчил, Арбитрын маргаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх
- Өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох
- Байгууллагын ажилтан албан хаагчдад хууль зүйн сургалт зохион байгуулах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгчөөр оролцох

## МӨНГӨН БАГЦ

- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, эрх зүйн актуудыг судалж холбогдох санал зөвлөмж боловсруулах
- Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэдээлэх, шаардлагатай тохиолдолд түүнтэй уялдсан дотоод баримт бичгийн төсөл боловсруулж хүргүүлэх
- Иргэн хуулийн этгээдтэй байгуулж буй гэрээ, хэлцлийн хууль зүйн үндэслэлийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хянах
- Өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар утсаар, цахим шуудангаар болон биечлэн уулзаж зөвлөгөө өгөх
- Гэрээ, баримт бичгийн төсөл боловсруулах, хянах

**НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ:**

- Эрүү, Иргэн, Захиргаа, Зөрчил, Арбитрын маргаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх
- Өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох
- Байгууллагын ажилтан албан хаагчдад хууль зүйн сургалт зохион байгуулах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгчөөр оролцох

# АЛТАН БАГЦ

- Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй баримт бичгүүд Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэх, тэдгээрийг шинэчлэх, дахин боловсруулах
- Үйлчлүүлэгчийн хүсэлтээр иргэн хуулийн этгээдтэй байгуулж буй гэрээ, хэлцлийн хууль зүйн үндэслэлийг хянах
- Бүх төрлийн эрх зүйн баримт бичгийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хянах, боловсруулах
- Байгууллагын үйл ажиллагаатай холбогдон гарсан эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах
- Өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар утсаар, цахим шуудангаар болон биечлэн уулзаж зөвлөгөө өгөх
- Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэдээлэх, шаардлагатай тохиолдолд түүнтэй уялдсан дотоод баримт бичгийн төсөл боловсруулж хүргүүлэх

**НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ:**

- Эрүү, Иргэн, Захиргаа, Зөрчил, Арбитрын маргаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх
- Өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох
- Байгууллагын ажилтан албан хаагчдад хууль зүйн сургалт зохион байгуулах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгчөөр оролцох
- Хууль зүйн бүхий л асуудлаар үйлчлүүлэгчийг төрийн болон төрийн бус аль ч байгууллагад төлөөлөх

# VIP

- Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй баримт бичгүүд Монгол улсын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянан үзэх, тэдгээрийг шинэчлэх, дахин боловсруулах
- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, эрх зүйн актуудыг судалж холбогдох санал зөвлөмж боловсруулах
- Үйлчлүүлэгчийн хүсэлтээр иргэн хуулийн этгээдтэй байгуулж буй гэрээ, хэлцлийн хууль зүйн үндэслэлийг хянах
- Гэрээ, баримт бичгийн төсөл боловсруулах, хянах
- Бүх төрлийн эрх зүйн баримт бичгийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр хянах, боловсруулах
- Байгууллагын үйл ажиллагаатай холбогдож гарсан эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах
- Өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар утсаар, цахим шуудангаар болон биечлэн уулзаж зөвлөгөө өгөх
- Үйлчлүүлэгчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрт нь мэдээлэх, шаардлагатай тохиолдолд түүнтэй уялдсан дотоод баримт бичгийн төсөл боловсруулж хүргүүлэх
- Шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хүрээнд мэдээлэл бэлтгэн хүргүүлэх
- Эрүү, Иргэн, Захиргаа, Зөрчил, Арбитрын маргаанд үйлчлүүлэгчийг төлөөлөх
- Өмгөөлөл хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулж хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчөөр оролцох
- Байгууллагын ажилтан албан хаагчдад хууль зүйн сургалт зохион байгуулах
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд үйлчлүүлэгчийн төлөөлөгчөөр оролцох
- Хууль зүйн бүхий л асуудлаар үйлчлүүлэгчийг төрийн болон төрийн бус аль ч байгууллагад төлөөлөх
- Тухайлсан эрх зүйн зүйн асуудлаар дүгнэлт гаргах

“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргийн шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй.”







“МАНАЙ ХУУЛИЙН ФИРМ НЬ ОЛОН ЖИЛ ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН, ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН БОЛОН ПРАКТИК ХЭРЭГЛЭЭ САЙТАЙ, ДАДЛАГА ТУРШЛАГАТАЙ, САЛБАРТАА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ХУУЛЬЧ, ӨМГӨӨЛӨГЧДӨӨС БҮРДСЭН.”

ӨМГӨӨЛЛИЙН
НИЙСЛЭЛ
АДВОКЭЙТС
ХХН


Утас 7722-2688, 9009-2688
И-мэйл law@niisleladvocate.mn
Вэб www.niisleladvocate.mn

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Багатойруу 9-р байрны 49 тоот

niisleladvocate

@niisleladvocate

@niisleladvocate